

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **БНА-2026/092/НА- СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/132  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- ТӨБЗГ-ын 2025 оны 692 дугаар тогтоолын дагуу өртгөө элэгдлээрээ элэгдүүлж дууссан 42,304.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахдаа устгалын актыг үйлдэж, санхүүгийн баримтад хавсаргаагүй;
- Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 32,508.0 мянган төгрөгийн 16.254 м.кв талбай бүхий газрыг цахим санд (egazar.gov.mn)-д 3600 м.кв-аар бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгөд 3 нэр төрлийн 15,399.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг 0 болон -1 жилээр бүртгэснээс тайлант хугацааны хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй орхигдуулсан зөрчил завсрын аудитаар илэрч, санхүүгийн

тайланд залруулахыг зөвлөсөн байхад байгууллагын нягтлан бодогч хэрэгжүүлж ажиллаагүй;

- Тайлант онд 10,596.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зах зээлийн судалгаагүй худалдан авахдаа шийдвэр гаргаагүй байна.

Аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,591,875.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас 1,518,429.0 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авч, үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Баянхонгор аймгийн Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллагаас 91 хувьтай үнэлсэн бөгөөд эрх бүхий байгууллагаас үнэлгээ ирээгүй байна.

Тус байгууллага 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр сурлагын амжилт сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 56.2 хувьтай, гарааны үнэлгээний дундаж 46.7 хувийн гүйцэтгэлтэй шалгагдсан байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРЛҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ



Хоёр: Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>254,954,823.59</b>	<b>466,414,781.91</b>
Банкинд байгаа бэлэн мөнгө	254,954,823.59	466,414,781.91
Төрийн сангийн харилцах	254,954,823.59	466,414,781.91
<b>АВЛАГА</b>	<b>7,625,598.00</b>	<b>0.00</b>
Бусад авлага	7,625,598.00	0.00
Ажиллагчидтай холбогдсон авлага	7,625,598.00	0.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>43,031,115.37</b>	<b>42,024,615.00</b>
Тусгай зориулалттай материал	34,896,435.37	36,172,915.00
Хангамжийн материал	8,134,680.00	5,851,700.00
Бичиг хэргийн материал	484,900.00	484,900.00
Аж ахуйн материал	7,567,600.00	5,345,000.00
Хүнсний материал	82,180.00	21,800.00
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>305,611,536.96</b>	<b>508,439,396.91</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,737,338,823.80</b>	<b>4,710,085,979.46</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>4,704,516,615.19</b>	<b>4,677,320,270.81</b>
Барилга, байгууламж, орон сууц	4,852,035,612.57	4,852,035,612.57
Хуримтлагдсан элэгдэл	-273,200,339.74	-353,739,400.66
Машин тоног төхөөрөмж(компьютер)	193,142,395.95	262,455,756.72
Хуримтлагдсан элэгдэл	-100,004,755.91	-99,851,696.10
Тавилга, аж ахуйн эд хогшил	163,652,621.48	145,878,028.48
Хуримтлагдсан элэгдэл	-132,585,649.16	-131,174,760.20
Номын фонд	1,476,730.00	1,716,730.00
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>32,822,208.61</b>	<b>32,765,708.65</b>
Программ хангамж	765,000.00	765,000.00
Хасагдуулга	-590,791.39	-647,291.35
Бусад биет бус хөрөнгө	32,648,000.00	32,648,000.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,737,338,823.80</b>	<b>4,710,085,979.46</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,042,950,360.76</b>	<b>5,218,525,376.37</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Өглөг</b>	<b>402,641.00</b>	<b>59,146,150.00</b>
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	1,398,400.00
Бусад өглөг	0	57,747,750.00
Ажиллагчидтай холбогдсон өглөг	402,641.00	0.00
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>402,641.00</b>	<b>59,146,150.00</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>402,641.00</b>	<b>59,146,150.00</b>
Засгийн газрын хувь оролцоо	421,793,425.59	421,793,425.59
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>4,619,251,180.87</b>	<b>4,737,343,660.78</b>
Өмнөх үеийн үр дүн	4,619,251,180.87	4,620,512,154.17
Тайлант үеийн үр дүн	0.00	116,831,506.61
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,503,113.30	242,140.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,042,547,719.76</b>	<b>5,159,379,226.37</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,042,950,360.76</b>	<b>5,218,525,376.37</b>

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,483,674,300.00</b>	<b>1,779,465,600.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,282,994,400.00</b>	<b>1,518,429,000.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,282,994,400.00	1,518,429,000.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>200,679,900.00</b>	<b>261,036,600.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,679,900.00	261,036,600.00
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>89,396,595.00</b>	<b>0.00</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого	70,000.00	0.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	89,326,595.00	0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,573,070,895.00</b>	<b>1,779,465,600.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ</b>	<b>1,002,432,177.08</b>	<b>1,143,395,608.20</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>889,121,577.08</b>	<b>1,013,832,578.69</b>
Үндсэн цалин	539,851,764.43	602,803,632.69
Нэмэгдэл	305,216,266.31	355,800,646.00
Унаа хоолны хөнгөлөлт	0.00	29,035,000.00
Урамшуулал	44,053,546.31	26,193,300.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>113,310,600.00</b>	<b>129,563,029.51</b>
Тэтгэврийн даатгал	78,382,020.68	89,834,893.57
Тэтгэмжийн даатгал	8,658,344.00	9,729,499.29
ҮОМШ өвчний даатгал	4,374,300.32	5,552,822.53
Ажилгүйдлийн даатгал	3,984,935.00	2,793,635.71
Эрүүл мэндийн даатгал	17,911,000.00	21,652,178.41
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>431,251,190.52</b>	<b>519,238,485.19</b>
<b>Тогтмол зардал</b>	<b>195,357,035.00</b>	<b>251,562,969.00</b>
Гэрэл цахилгаан	7,668,135.00	11,280,969.00
Түлш, халаалт	185,779,300.00	238,632,000.00
Цэвэр, бохир ус	1,909,600.00	1,650,000.00
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>74,141,752.46</b>	<b>97,141,560.85</b>
Бичиг хэрэг	9,200,800.00	8,357,300.00
Тээвэр, шатахуун	3,478,500.00	1,345,650.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	13,161,050.00	11,671,100.00
Бараа материал акталсны зардал	0.00	5,673,520.37
Урсгал засвар	3,235,000.00	2,390,000.00
Хоол	36,010,090.00	57,084,300.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	9,056,312.46	10,619,690.48
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>131,515,637.82</b>	<b>132,425,094.34</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	20,867,733.57	11,088,700.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,289,123.00	0.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	106,358,781.25	121,336,394.34
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,236,765.00</b>	<b>38,108,861.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,148,900.00</b>	<b>36,635,230.00</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	24,636,500.00	36,635,230.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,512,400.00	0.00
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,087,865.00	1,473,631.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (II)</b>	<b>139,387,527.64</b>	<b>116,831,506.61</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (V)</b>	<b>139,387,527.64</b>	<b>116,831,506.61</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,483,674,300.00</b>	<b>1,779,465,600.00</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	1,282,994,400.00	1,518,429,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,282,994,400.00	1,518,429,000.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>200,679,900.00</b>	<b>261,036,600.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,679,900.00	261,036,600.00
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>70,000.00</b>	<b>0.00</b>
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	70,000.00	0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,483,744,300.00</b>	<b>1,779,465,600.00</b>
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ</b>	<b>1,009,655,134.08</b>	<b>1,136,172,651.20</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>899,538,134.08</b>	<b>1,006,456,621.69</b>
Үндсэн цалин	567,894,620.40	568,224,531.78
Нэмэгдэл	301,743,802.00	383,003,789.91
Унаа хоолны Хөнгөлөлт	0.00	29,035,000.00
Урамшуулал	29,899,711.68	26,193,300.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,117,000.00	129,716,029.51
Тэтгэврийн даатгал	74,951,600.00	82,361,129.51
Тэтгэмжийн даатгал	8,817,800.00	11,838,700.00
ҮОМШӨ-ний даатгал	4,391,200.00	5,919,400.00
Ажилгүйдлийн даатгал	4,391,200.00	5,919,400.00
Эрүүл мэндийн даатгал	17,565,200.00	23,677,400.00
<b>Бараа үйлчилгээний урсгал зардал</b>	<b>195,607,035.00</b>	<b>251,562,969.00</b>
Тогтмол зардал	195,607,035.00	251,562,969.00
Гэрэл, цахилгаан	7,668,135.00	11,280,969.00
Түлш, халаалт	185,779,300.00	238,632,000.00
Цэвэр, бохир ус	2,159,600.00	1,650,000.00
<b>Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал</b>	<b>35,708,000.00</b>	<b>57,601,150.00</b>
Хоол	35,708,000.00	57,601,150.00
Бусад бараа үйлчилгээний зардал	93,167,114.03	86,333,071.48
Урсгал засвар	2,985,000.00	8,000,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	11,898,812.46	12,149,690.48
Бараа үйлчилгээний бусад зардал	41,601,783.57	22,570,750.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,762,923.00	7,479,400.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	24,318,330.00	34,659,600.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,512,400.00	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,087,865.00	1,473,631.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>1,334,137,283.11</b>	<b>1,531,669,841.68</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>149,607,016.89</b>	<b>247,795,758.32</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,800,750.00	36,335,800.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>9,800,750.00</b>	<b>36,335,800.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-9,800,750.00</b>	<b>-36,335,800.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>139,806,266.89</b>	<b>211,459,958.32</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>115,148,556.70</b>	<b>254,954,823.59</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>254,954,823.59</b>	<b>466,414,781.91</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	421,793,425.59	1,503,113.30	4,479,863,652.23	4,903,160,191.12
<b>Залруулсан үлдэгдэл</b>	421,793,425.59	1,503,113.30	4,479,863,652.23	4,903,160,191.12
2024 оны 01-р сарын 31-ний үлдэгдэл	<b>421,793,425.59</b>	<b>1,503,113.30</b>	4,479,863,652.23	<b>4,903,160,191.12</b>
Тайлант үеийн үр дүн			139,387,527.64	139,387,527.64
2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	421,793,425.59	1,503,113.30	4,619,251,180.87	5,042,547,719.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			1,260,973.30	1,260,973.30
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>421,793,425.59</b>	<b>1,503,113.30</b>	<b>4,620,512,154.17</b>	<b>4,412,165,974.80</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(1,260,973.30)		(1,260,973.30)
Тайлант үеийн үр дүн			116,831,506.61	116,831,506.61
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<b>421,793,425.59</b>	<b>242,140.00</b>	<b>4,737,343,660.78</b>	<b>5,159,379,226.37</b>

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>1,591,875,300.00</b>	<b>1,518,429,000.00</b>	<b>73,446,300.00</b>	95.39
Улсын төсвөөс	1,591,875,300.00	1,518,429,000.00	73,446,300.00	95.39
Урсгал	1,591,875,300.00	1,518,429,000.00	73,446,300.00	95.39
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,591,875,300.00	1,518,429,000.00	51,965,702.25	97.83
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>1,399,004,700.00</b>	<b>1,143,548,608.20</b>	255,456,091.80	81.74
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,243,486,300.00</b>	<b>1,013,832,578.69</b>	229,653,721.31	81.53
Цалин	742,969,100.00	568,224,531.78	174,744,568.22	76.48
Цалингийн тусгай нэмэгдлүүд	500,517,200.00	445,608,046.91	54,909,153.09	89.03
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>155,518,400.00</b>	<b>129,716,029.51</b>	25,802,370.49	83.41
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	130,635,500.00	106,038,629.51	24,596,870.49	81.17
Эрүүл мэндийн даатгалын хураамж	24,882,900.00	23,677,400.00	1,205,500.00	95.16
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>200,396,000.00</b>	<b>170,796,390.48</b>	<b>29,599,609.52</b>	<b>453.53</b>
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	76,954,700.00	57,601,150.00	19,353,550.00	74.85
Хоол	76,954,700.00	57,601,150.00	19,353,550.00	74.85
Мэдээлэл технологийн зардал	19,341,700.00	18,149,690.48	1,192,009.52	93.84
Бусад бараа үйлчилгээний зардал	61,914,600.00	52,906,550.00	9,008,050.00	85.45
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	7,525,400.00	7,479,400.00	46,000.00	99.39
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	34,659,600.00	34,659,600.00	-	100.00
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	1,599,400,700.00	1,314,344,998.68	285,055,701.32	82.18
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	254,954,823.59	-		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	466,414,781.91		

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 281,754.1 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

### **Залруулсан алдаа:**

1. Тайлант хугацаанд олгосон 273,271.4 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан байна.
2. Байгууллагын нягтлан бодогч цалингийн зардлын 8,482.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалт, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын гуравдугаар бүлгийн 3.6 ба 3.7 дахь заалт, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх болон Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 104,506.6 мянган төгрөгийн 7 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 232.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 78,277.9 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 3 албан шаардлага өгч, 25,996.4 мянган төгрөгийн 2 зөрчилд удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 104,506.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааны 32,648.0 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал тул материаллаг бусаар тооцсон, аудитаар илэрсэн 71,858.6 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### **5.1. Төлбөрийн акт**

1. Тайлант онд 175.0 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар 175.0 мянган төгрөгийг төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалаар чиглүүлэгч багшаар ажилласан багшид 573.0 мянган төгрөгийг олгохдоо хувь хүний орлогын албан татварын суутган тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, ажил, үйлчилгээний орлогыг шууд бус орлогод хамруулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар 57.3 мянган төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов

## **5.2. Албан шаардлага**

1. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 32,508.0 мянган төгрөгийн 16.254 м.кв талбай бүхий газрыг цахим санд (egazar.gov.mn)-д 3600 м.кв-аар бүртгэсэн, санхүүгийн тайланд бүртгэлтэй 140.0 мянган төгрөгийн 70 м.кв газрын гэрчилгээ гараагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйл, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тооцоо нийлж, газрын гэрчилгээг гаргуулж, нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Төрийн аудитын байгууллагаас 2025 оны 11 дүгээр сард хийсэн завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг арга хэмжээ авч ажиллаагүйгээс хүүхдээ асрах чөлөөтэй албан хаагчдын нийгмийн даатгалыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр мэдээлэхдээ даатгуулагчийн кодыг 01001-ээр мэдээлсэн, 5 дугаар сард нэг албан хаагчид олгосон 303.5 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын мэдээнд мэдээлээгүй орхигдуулсан, тухайн байгууллагаас нийгмийн даатгалын газарт төлсөн шимтгэлийн дүн мэдээнээс 2,464.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, нийгмийн даатгалын сангаас ирүүлсэн ажил олгогчийн шимтгэлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлийн товчоогоор тус байгууллага оны эцэст 556.7 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь “Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” заалт, УСНББОУС-19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, НББОУС-37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх болон Үнэлгээ ба хуваарилалт, Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин зөрүүтэй мэдээлсэн, даатгуулагчийн кодны зөрүүг залруулж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

3. Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дүгээр сарын 04-ний өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 692 дүгээр тогтоолын дагуу өртгөө элэгдлээрээ элэгдүүлж дууссан 42,304.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахдаа устгалын актыг үйлдэж, санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “Үнэн зөв байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу 42,304.7 мянган төгрөгийн хөрөнгийг устгасан нотлох баримтыг санхүүгийн баримтад хавсарган зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

## **5.3. Зөвлөмж**

1. Үндсэн хөрөнгөд 3 нэр төрлийн 15,399.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг 0 болон -1 жилээр бүртгэснээс тайлант хугацааны хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй орхигдуулсан зөрчил завсрын аудитаар илэрч, санхүүгийн тайланд залруулахыг зөвлөсөн байхад байгууллагын нягтлан бодогч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.26-т “Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хөрөнгийн ашиглах жилийг тогтоолгон, хөрөнгийн ашиглах жилийн санхүүгийн программд бүртгэж, элэгдлийн зардалд хяналт тавьж байх

2. Тайлант онд "Эх арцат" хоршооноос компьютер худалдан авсан компьютерын үнийн саналыг шаардсан боловч ирүүлээгүй, захирал хөрөнгө зарцуулах тушаалыг тухай бүрд гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна” гэсэн заалт болон УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг тухай бүрд гаргаж, санхүүгийн баримтад хавсаргаж, биелэлтийг тооцож байх

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацаанд олгосон 273,271.4 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан байна.	1	273,271.4			1	273,271.4	1	273,271.4				
Байгууллагын нягтлан бодогч цалингийн зардлын 8,482.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнасан байна.	1	8,482.8			1	8,482.8	1	8,482.8				
<b>ДҮН</b>	<b>2</b>	<b>281,754.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>281,754.1</b>	<b>2</b>	<b>281,754.1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>
Бараа материалыг шаардах хуудасгүйгээр олгосон байна.	1	175.0	1	175.0								
Үндсэн хөрөнгөд 3 нэр төрлийн 15,399,910 төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг 0 болон -1 жилээр бүртгэснээс тайлант хугацааны хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй орхигдуулсан зөрчил завсрын аудитаар илэрч, санхүүгийн тайланд залруулахыг зөвлөсөн байхад байгууллагын нягтлан бодогч хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	15,399.9					1	15,399.9				
Тайлант онд "Эх арцат" хоршооноос компьютер худалдан авсан компьютерын үнийн саналыг шаардсан боловч ирүүлээгүй, захирал хөрөнгө зарцуулах тушаалыг тухай бүрд гаргаагүй байна.	1	10,596.6					1	10,596.6				

A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хүүхдээ асрах чөлөөтэй М.Нямтогтох, Б.Цэрэнбат нарын нийгмийн даатгалыг 660,000 төгрөгөөр мэдээлэхдээ даатгуулагчийн кодыг 01001-ээр мэдээлсэн, Ц.Нарантуяагийн 5 дугаар сарын цалинг 303.5 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, тухайн байгууллагаас нийгмийн даатгалын газарт төлсөн шимтгэлийн дүн мэдээнээс 2,464.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, нийгмийн даатгалын массиваар тус байгууллага 556.7 мянган төгрөгийн өглөгтэй байхад тус өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	3,325.1			1	3,325.1						
Тайлант онд ТӨБЗГ-ын 2025 оны 12 дүгээр сарын 04-ний өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 692 дүгээр тогтоолын дагуу өртгөө элэгдлээрээ элэгдүүлж дууссан 42,304.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахдаа устгалын актыг үйлдэж, санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.	1	42,304.8			1	42,304.8						
Байгууллагын даргын 2025.12.18-ны өдрийн А/53 дугаар тушаалаар чиглүүлэгч багшаар ажилласан багшид 573.0 мянган төгрөгийг олгохдоо хувь хүний орлогын албан татварын суутган тооцоогүй байна.	1	57.3	1	57.3								
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>71,858.6</b>	<b>2</b>	<b>232.3</b>	<b>2</b>	<b>45,629.9</b>	<b>2</b>	<b>25,996.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		